

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ: ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ

Нээлттэй Нийгэм Форум нь Монголын Хуульчдын Холбооны Эрүүгийн эрх зүйн хороотой хамтран “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал” сэдэвт 8 цуврал хэлэлцүүлгийг мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгч, их дээд сургуулийн багш нар, хохирогч хамгааллын чиглэлээр ажилладаг ТББ-ын ажилтан зэрэг нийт 150 орчим мэргэжилтнийг оролцуулан 2018 оны 4-р сарын 20-ны өдрөөс 5-р сарын 22-ны хооронд зохион байгуулсан билээ. Хэлэлцүүлгийн үеэр Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг авч хэлэлцлээ.

Эхний 6 цуврал хэлэлцүүлгийг тодорхой ажил мэргэжлийн хүрээнд хийсэн бол сүүлийн хоёр хэлэлцүүлгийг бүх талын төлөөллийг оролцуулан зохион байгуулснаараа онцлогтой. Үүний дүнд хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг аль болох олон талын оролцоог ханган тодорхойллоо. Хуульчид, хууль сахиулагчдын өмнө тулгарч буй асуудал нь хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, асуудлыг шийдвэрлэх оновчтой шийдлийг эрэлхийлэхэд оршиж буй тул гарсан бүхий л санал шүүмжийг нэг бүрчлэн тусгахыг эрмэлзсэн болно. Үүний зэрэгцээ бүх асуудалд бус зарим нэгд зарчмын зөрүүтэй байр суурь, эсхүл тодорхой санал гарсныг тусгасны улмаас бичиглэл, найруулгын хувьд нэг мөр болоогүйд хүлцэл өчье.

Хэлэлцүүлгээс гарсан тулгамдсан асуудлыг нийтлэг болон тусгай асуудлууд хэмээн хоёр бүлгээр танилцуулж байгаа бөгөөд дээрх 4 хуулийн хүрээнд нийтлэг 90, тусгай 266 тулгамдсан асуудлыг тодорхойлоод байна. Энэхүү хуулийн шүүмж нь эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль хэрэгжүүлэх албан тушаалтныг чадавхжуулах, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх дүрэм журам, удирдамж, заавар зөвлөмж, гарын авлага боловсруулахад хувь нэмэр болно гэдэгт найдаж байна.

Хэлэлцүүлэгт оролцсон хуульчид, хууль сахиулагчид, иргэний нийгмийн ажилтнуудын нэрсийг хавсаргасан болно.

Нэг. Нийтлэг асуудал

- 1.1. Байгаль орчинтой холбоотой хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх эдийн засаг, хүний нөөц, чадавхын боломж байхгүй, ганц байцаагч энэ бүх хэрэг, зөрчлийг хянаж, газар дээр нь үзлэг хийн нотлох баримт бүрдүүлж, бараг мөрдөгчийн ажил хийх боломж үнэхээр байхгүй болохоор орон нутгийн захиргаанд маш их ачаалал, хүндрэл учирч байна. Аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа их явагддаг газар байгаль орчны хэрэг, зөрчил их гардаг. Гэтэл энэ их ажлын ачаалал, санхүү, хүний нөөцийг тооцоогүй, нөхцөлийг бүрдүүлээгүй үед хууль хангалтгүй хэрэгжихэд хүрч байна.
- 1.2. Зөрчил гаргасан хүн, хуулийн этгээд, хууль ёсны төлөөлөгчийг албадан ирүүлэх, оргон зайлсан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан эрэн сурвалжлах ажиллагаа явуулах талаар огт тусгаагүй. Үүний улмаас зөрчлийн холбогдогч хаана байгаа нь тогтоогдохгүй, дуудсан хугацаанд ирэхгүй, зөрчил шалгах ажилд хүндрэл учруулах, зөрчлийг шийдвэрлэхэд хугацаа алдаж байна. Тиймээс эрэн сурвалжлах ажиллагааны үндэслэл, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтныг тодорхой болгох шаардлагатай.
- 1.3. Цагдаагийн эрх бүхий албан тушаалтан зөрчил гаргасан этгээдийг ноцтой зөрчил гаргахад хүргэхгүй байх, согтуурах мансуурах донтой эсэхийг тогтоох, биеийн байцаалт тодорхойгүй этгээд зөрчил үйлдсэн зэрэг тохиолдолд харьяалах шүүхэд мэдэгдэж, 72 цаг хүртэл хугацаагаар албадан саатуулж болно гэсэн заалт нэмэх шаардлагатай. Зөрчил үйлдсэн этгээдийг согтуурах, мансуурах донтой эсэхийг тогтоох эмнэлгийн дүгнэлт гаргуулах, нотлох баримт бүрдүүлэхэд хугацаа хангалтгүй байна.
- 1.4. Зөрчлийн хэргийн нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд үнэлэх шаардлагатай.
- 1.5. Хуульд заасан “даруй” гэсэн хугацаа тодорхойгүй байна.

Санал: Сургалт шаардлагатай

- 1.6. Санхүүгийн зөрчлийг хэрхэн шалгах чиглэлээр тодорхой заавар шаардлагатай. Санхүүгийн зохицуулах хороо олон шат дамжлагын дараа тухайн зөрчлийг хүлээн авдаг бөгөөд тухайн зөрчлийг хэрхэн шалгахад мэргэжилтнүүд нь мэддэггүй.
- 1.7. Хууль зүйн сайдын 2015 оны А188 тоот тушаалаар баталсан “Бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах журам”-д уг үйл ажиллагааг зохицуулсан боловч, тус журмаас тодорхой зохицуулалтыг хуульчилж өгөөгүйгээс нийт зөрчлийн 80 орчим хувийг эзэлдэг бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирсан. Тухайлбал тээврийн хэрэгсэл ашиглаж үйлдсэн зөрчлийг хяналтын камераар баримтжуулсан хэдий ч заавал зөрчил гаргагчийг ирүүлэх, бэлэн бус торгуулийн төхөөрөмжөөс цахим хэлбэрээр шийтгэлийн хуудас хэвлэх тохиолдолд заавал цаасан материал давхар хөтлөхийг прокурор, шүүхээс шаардаж байгаа нь энэ төрлийн зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлтэд сөргөөр нөлөөлж байна. Хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн 6.6 дугаар зүйлд заахдаа бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах зохицуулалтыг орхигдуулсан. Тиймээс бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах хуулийн заалт, холбогдох журмын хэрэгжилтийг тодорхой болгох шаардлагатай. Шийдвэрийн биелэлтийг эрх бүхий албан тушаалтан хариуцах нь практикт хэрэгжүүлэх боломжгүй байна. Ялангуяа бага хэмжээний торгууль дээр ямар ч үр ашиггүй зохицуулалт юм. Тухайлбал, нэг аймгийн цагдаагийн ажилтан 10,000 төгрөгийн торгуулийг төлүүлэхээр нөгөө аймаг руугаа томилолт авч очоод шүүхэд өгч шийдвэрлүүлэх шаардлага үүснэ гэсэн үг.
- 1.8. Зөрчлийн тухай хуулиас илүү нарийвчлан зохицуулсан хууль байна. Тухайлбал, Хог хаягдлын тухай хуулиар зөрчил үйлдвэл хүлээлгэх хариуцлагыг давхар заасан. Зөрчлийг шалгахдаа процесс хуулиа

барьж, шийтгэл оногдуулахдаа чиглэлийн хуулиа барьж байгаа нь зөрчилдөж байна. Өөр нэг жишээ бол Нийгмийн даатгалын тухай хууль болно.

- 1.9. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчилтэй тэмцэх ажил ур чадвар шаардаж байгаагаас хүссэн үр дүнд хүрэхгүй байна. Гэр бүлийн хүчирхийллийн хуулийг дагаж гарсан 31 журам байна. Эдгээрээс 21 журмыг нийгмийн ажилтан хэрэгжүүлэхээр байгаа ч нийгмийн ажилтныхаа орон тоог нэмээгүй. Дээр нь нэмээд хүүхэд хамгаалах 10 журмыг хариуцуулсан.
- 1.10. Хялбаршуулсан журмаар “газар дээр нь шийдвэрлэх” гэсэн тодорхой зохицуулалтыг хуульд тусгаж, бүрдүүлэх материалыг хөнгөвчлөх шаардлагатай байна. Одоогийн зохицуулалтаар 3 хүртэл хоногийн хугацаанд шалгаж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа ба зөрчлийг илэрмэгц газар дээр шийдвэрлэх гэсэн зохицуулалт байхгүйгээс гомдол, мэдээлэл хүлээн авч 3 хоногийн дотор шалгаж байгаа нь иргэдэд болон эрх бүхий албан тушаалтанд хүндрэл учруулж байна.
- 1.11. Прокурор хянах явцдаа тухайн зөрчилд холбогдогчдоос мэдүүлэг авах, өөрөө зөрчил үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн гэдгийг нотлох зэрэг олон бичиг баримт шаардаж байгаа нь эрх бүхий албан тушаалтан, иргэдэд ихээхэн чирэгдэл учруулж байна. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд тавьж байгаа прокурорын хяналтыг багасгах, шүүхээр шийдвэрлэх зөрчлийг шүүх хурал хийхгүйгээр шүүгч шийдвэрлэх зохицуулалтыг тусгах шаардлагатай. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хууль тогтоомж, хүний эрх, эрх чөлөө зөрчигдсэн гэж үзвэл оролцогч прокурорт гомдол гаргасны үндсэн дээр шаардлагатай материалыг татаж хянадаг байх шаардлагатай. Мөн зөрчил, түүнд холбогдох материалыг жагсаалтаар бүртгэж, зөрчлийн тоо бүртгэлийг хянах зохицуулалтыг тусгах нь зүйтэй. Цагдаагийн байгууллагын алба хаагчид жилд дунджаар 1,3-1,5 сая зөрчлийг шийдвэрлэж байгаа бөгөөд дээрх тооны зөрчлийг хянахад прокурорт мөн ачаалал үүсэж байна. Одоогийн байдлаар төсөв, санхүүгийн хүрэлцээгүйгээс цагдаагийн байгууллагад зөрчил шалган шийдвэрлэх дагнасан алба хаагчид ажиллахгүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг сахиулах чиг үүргийг хэрэгжүүлдэг алба хаагчид зөрчлийг шалган шийдвэрлэж байгаа ба хэрэг, материал бүрийг прокурорт хянуулах, дугаар авах, шүүх хуралд оролцох зэрэг ачаалал үүсэж, хуулиар харьяалуулсан бусад чиг үүргийн ажил алдагдах, иргэдэд үйлчлэх цагдаагийн үйлчилгээ буурах хандлага үүсэж байна.

Хоёр. Тусгай асуудал

- 2.1. Хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан ёсны хэл бичгээр хөтөлж баталгаажуулна” гэсэнтэй тус хуулийн 3.4 дүгээр зүйлийн 6 дах хэсэгт заасан “эрх бүхий албан тушаалтан зөрчил шалгах ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулах, эсхүл энэ хуулийн 6.6 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад заасан үндэслэлээр хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэхэд хэлмэрч орчуулагч оролцуулахгүй байж болно.” гэсэн нь зөрчилдөж байна.
- 2.2. Хуулийн 1.8 дугаар зүйлд “зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэр, энэ хуульд заасан харьяаллын дагуу явуулна” гэсэн нь тусгайлсан хуульд хэргийн харьяаллыг тодорхойлсон тохиолдол байдагтай зөрчилдөхөөр байгааг анхаарч үзэх нь зүйтэй.
- 2.3. Хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.6 дах заалтад олон нийтийн цагдаагийн шалгах зөрчлийн харьяаллыг тогтоосон бөгөөд олон нийтийн цагдаа нь тухайн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг хийх чадавхтай эсэх нь эргэлзээтэй байна. Хэрэв олон нийтийн цагдаа зөрчлийг шалгах явцад хүний эрх, эрх чөлөөг зөрчвөл хэрхэх, хэн хариуцлага хүлээх нь тодорхойгүй.
- 2.4. Хуулийн 1.8 дугаар зүйлийн 7 дах заалтад Эрүүгийн шүүхийн харьяалан шийдэх зөрчлийг зааж, зөрчлийн хэрэг бүртгэлтийг нь 1.8 дугаар зүйлийн 9 дэх заалтаар цагдаагийн байгууллага явуулахаар заасан бол

1.8 дугаар зүйлийг 8 дах заалтад Захиргааны, Иргэний шүүхэд харьяалах зөрчлийн хэрэг бүртгэлтийг хэн хийх нь тодорхойгүй үлдсэн.

- 2.5. Хуулийн 1.10 дугаар зүйлд заасан “хэтэрсэн хугацааг сэргээх” тухай ойлголтыг эрх бүхий албан тушаалтнууд сайн мэдэхгүй байна.

Санал: Сургалт шаардлагатай.

- 2.6. Хуулийн 1.12 дугаар зүйлийн 5 дах заалтад дээд шатны прокурор гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянан шийдвэрлэхээр заасан бол ЭХХШТХ-ийн 15.7 дугаар зүйлийн 2 дах заалтаар 14 хоногийн дотор гомдлыг хянахаар байна. Энэ тохиолдолд маргаан үүсвэл хэрхэн зохицуулах нь тодорхойгүй.

Санал: Сургалт шаардлагатай.

- 2.7. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг ЭХХШТХ-ийн 15-р бүлэгт заасан нийтлэг журмыг баримтлан явуулахаар хуулийн 1.12 дугаар зүйлийн 8 дах заалтад заасан бөгөөд энэ журмаар гомдлоо хэдэн шатны байгууллагад гаргаж болохоор байгаа бол ЗШШТХ-иар 2 шатны прокурорт гаргахаар хязгаарласан байна.

Санал: Сургалт шаардлагатай.

- 2.8. Орон нутгийн болон төвөөс алслагдсан суманд ажиллаж байгаа цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагчид хуулийн 1.13 дугаар зүйлийн 3 дах заалтад заасны дагуу 3 хоногт багтаан зөрчлийн гомдол, мэдээллийг шийдвэрлэхэд хүндрэлтэй байгаа тул хугацааг уртасгах шаардлагатай байна.
- 2.9. Хуулийн 3.6 дугаар зүйлд “ЭХХШТХ-ийн 12.3 дах заалтад заасны дагуу албадан ирүүлэх” гэж нэмж тусгах шаардлагатай байна.

Санал: Сургалт шаардлагатай.

- 2.10. Зөрчлийн тухай хуулийн 3.8 дугаар зүйлийн 1 дэх заалтад “Тээврийн хэрэгсэл ашиглан энэ хуулийн Арван дөрөв дүгээр бүлэгт заасан зөрчил үйлдсэн нь автомат ажиллагаатай зураг-дүрс бичлэгийн техник, хэрэгслээр бэхжүүлэгдсэн бол тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчид энэ хуульд заасан шийтгэл оногдуулна” гэсэн ч, шүүх дээр замын камерын бичлэгийг нотлох баримтад тооцдоггүй нь хэрэг унах нэг шалтгаан болж байна.

Санал: Сургалт шаардлагатай.

- 2.11. Хуулийн 4.3 дугаар зүйлийн 2 дах заалтад “орон байранд үзлэг хийх” зөвшөөрлийг прокуророос авахаар заасан нь хангалттай биш тул, өөр нөхцөлийг тухайлбал, “ажлын байранд үзлэг хийх” гэх мэт нөхцөлийг нэмж тусгах шаардлагатай.

2.12. Хуулийн 4.3 дугаар зүйлийн 11 дэх заалтад үзлэгийг албадан гүйцэтгэж болохоор заасан ч албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх тусгай журам байхгүй байна. Тухайлбал, Согтуугаар машин барьж зөрчил гаргасан жолооч шалгуулахгүй, хаалга, цонхоо хаачхаад саад учруулаад байвал албадлагын арга хэмжээг яаж авч хэрэгжүүлэх нь тодорхойгүй.

Санал: Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх тусгай журам гаргах.

2.13. Хуулийн 4.5.2-т эд зүйл, баримт бичиг хураан авах бол ЭХХШТХ-ийн 24.4-р зүйлд заасан журмыг баримтална гэснийг ЗШШТХ-ийн 4.2 дугаар заалтаар зохицуулж болохоор байна.

2.14. Хуулийн 4.8 дугаар зүйлд заасан “мэдүүлэг авах” гэсэн нэр томьёо нь Цагдаагийн албаны тухай хуулийн 4 бүлэгт заасан цагдаагийн алба хаагчаас явуулах тодорхой ажиллагааны нэг болох “Тайлбар авах” гэсэнтэй зөрчилдөж байна.

Санал: Сургалт шаардлагатай.

2.15. Хуулийн 4.8 дугаар зүйлийн 9 дэх заалтад заасан “мэдүүлэг өгч байгаа хүнд эд мөрийн баримт үзүүлэх, тухайн зөрчлийн талаар бусад хүнээс өгсөн мэдүүлгийг танилцуулж, энэ талаар мэдүүлэг авч болно” гэсний дагуу гэртээ агсан согтуу тавьж зөрчил гаргасан хүний талаар эхнэр, хадам ээж, аав г.м хүмүүсийн өгсөн мэдүүлгийг уншуулах нь гэр бүлийн хүчирхийлэл үүсэх шалтгаан болох тохиолдол гарч байна.

Санал: Сургалт шаардлагатай.

2.16. Хуулийн 4.10 дугаар зүйлийн 1 дэх заалтад “шинжилгээ хийх зорилгоор хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтнаас хэв загвар, дээж авч болно” гэсэн нь хүний биеэс шинжилгээ хийх зорилгоор дээж авах ажиллагаа прокурорын зөвшөөрөлгүй хийхээр байгаа бөгөөд энэ нь хүний халдашгүй байх эрхийг зөрчихөөр байна.

2.17. Хуулийн 4.11 дүгээр зүйлийн 2 дах заалтад шинжилгээ хийх төрөлд “Хүний биед учирсан гэмтлийн зэргийг тогтоох”, “согтуурлын зэрэг тогтоох” гэж нэмэлт оруулах шаардлагатай. Зөрчлийг ялган зүйлчлэх, хор уршгийг тогтоох, цаашилбал ял шийтгэлийг ялгамжтай оногдуулах боломжийг бүрдүүлэхэд ач холбогдолтой.

Санал: Сургалт шаардлагатай.

2.18. Хуулийн 4.11 дүгээр зүйлийн 2 дах заалтад “зөрчил гаргагчийн мансуурсан, согтуурсан, гэмтлийн зэрэг тогтоох”-д прокурорын зөвшөөрөл авах шаардлагагүй гэсэн өөрчлөлт оруулах нь зүйтэй.

2.19. Хуулийн 4.12 дугаар зүйлийн дагуу хураан авсан эд зүйлтэй холбогдох харилцааг ЭХХШТХ-ийн холбогдох заалтаар зохицуулахаар байна. Гэтэл ЭХХШТХ-ийн 21.5.2-т “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тухайн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг шилжүүлсэн, хадгалсан, худалдан борлуулсан, устгасан тохиолдолд шүүхийн шийдвэрээр эзэмшигчид нь адил төрөл, чанарын эд зүйлийг олгох, эсхүл үнийг төлнө” гэсэн нь зөрчил гаргагчид завших боломж олгохоор байна. Тухайлбал, тарифын бус

хязгаарлалттай их хэмжээний эм оруулж оруулж ирснийг саатуулаад, борлуулаад, борлуулсан үнийг нь буцааж олгохоор байна. Өөрөө худалдан борлуулах шаардлагагүй.

Санал: Сургалт шаардлагатай.

2.20. Хуулийн 4.13 дугаар зүйлийн 7 дах заалтын дагуу хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлийн маягтыг Улсын ерөнхий прокурор батлахаар байгаа бөгөөд хуулийн энэ заалтын дагуу зөрчил болгонд тэмдэглэл үйлдэх нь ихээхэн цаг хугацаа шаардаж байна. Тухайлбал, Замын цагдаа бүс бүслээгүй, гэрэл дохио зөрчсөн, 1-р эгнээгээр зорчсон зэрэг зөрчлийг илрүүлж, зам дээр зогсоогоод тэмдэглэл хөтлөх хугацаанд өөр ноцтой гэмт хэргийн шинжтэй зөрчил гарах магадлалыг өсгөж байна.

Санал: Хялбаршуулсан тэмдэглэлийн загварыг боловсруулах шаардлагатай.

2.21. Хуулийн 6.6 дугаар зүйлийн дагуу хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх явцад гомдол гаргах эрхийг тусгаагүй нь хүний эрхийн зөрчил үүсгэхээр байна.

2.22. Хуулийн 6.6 дугаар зүйлд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэхэд бэлэн бусаар торгууль оногдуулах заалтыг нэмж оруулах шаардлагатай байна.

2.23. Хулгайн хэргийн эзэн холбогдогч илрэхгүй байсаар хэрэг бүртгэлтийн хугацаа дуусдаг. Хэрэв хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад эзэн холбогдогч илэрвэл, хэргийг дахин сэргээх тухай заалт нэмэх шаардлагатай.

Санал: Хуулийн 6.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хөөн хэлэлцэх хугацааны дотор хэргийг дахин сэргээх” тухай заалт нэмэх

2.24. Хуулийн 7.2 дугаар зүйлийн 5 дах хэсэгт торгуулийг хэсэгчлэн төлөх хэмжээ, хугацааг шийтгэлийн хуудсанд бичихээр тусгасан бөгөөд “торгууль”-ийг хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг хэн гаргах, ямар шалгуур үзүүлэлт тавих, хэдий хэмжээний төлбөрийг, ямар журмаар хэсэгчлэн төлүүлэх зэрэг нь тодорхой бус байна.

2.25. Хуулийн 7.4 дүгээр зүйлийн 2 дах заалтад “18 насанд хүрээгүй бол” гэсэн нь хэрэг бүртгэлийн хугацаанд 18 нас хүрээгүй байх уу, эсвэл 1 жилийн дотор 18 нас хүрээгүй байх уу гэдэг нь тодорхойгүй байна.

2.26. Хуулийн 7.6 дугаар зүйлд шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргах харьяаллыг тогтоож өгчээ. Гэтэл оролцогч нь энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 7, 8 дахь заалтад заасан эрүүгийн, иргэний, захиргааны шүүхээр шийтгэл ногдуулсан хэрэгт гомдол гаргах боломжгүй байна. Мөн шүүхийн үйл ажиллагаанд давж заалдах гомдол гаргах эрхийг хаасныг нээж өгөх нь зүйтэй. Баривчлах болон бусад шийтгэл ногдуулсан шийтгэлд давж заалдах гомдол гаргасан хугацаанд шүүхийн шийдвэр түдгэлздэг байх ёстой. Хэргийн оролцогчид ялангуяа баривчлах шийтгэл эдэлсний дараа давж заалдах шүүх хуралдаанаар анхан шатны шүүхийн шийдвэр хүчингүй болох боломжтой тул иргэн хилсдэнэ.

2.27. Хуулийн 9.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан саатуулах хугацааг “харьяалах шүүхэд мэдэгдэж 72 цаг хүртэл хугацаагаар саатуулах” гэж өөрчлөх шаардлагатай. 24 цаг хүртэлх хугацаагаар саатуулсан хугацаа амралтын өдрүүдэд дуусахад шүүх ажилладаггүйгээс дахин 48 цаг хүртэл хугацаагаар саатуулах

боломжгүй байдаг амралтын өдрүүдэд зөрчил гаргасан хүнийг хаана байлгах нь тодорхойгүй болж, ажиллагаанд хүндрэл учирдаг.

- 2.28. Зөрчил гаргасан этгээд нь тогтоогдоогүй, оргон зайлсан тохиолдолд зөрчлийн хэргийг “түдгэлзүүлэх” зохицуулалтыг тусгах. Түдгэлзүүлээгүй тохиолдолд сар бүр олон зөрчлийн хэргүүд эрх бүхий албан хаагчдад ачаалал үүсгэж байна.

Тайлбар: Эрх зүйн байдлыг дордуулна.

- 2.29. Хуулийн 9.1 дүгээр зүйлд Зөрчлийн тухай хуулийн 5.7, 6.21 дүгээр зүйлд заасан “гүтгэх”, “мөрийтэй тоглохыг зохион байгуулах” зөрчлийг нэмэх нь зүйтэй. Учир нь дээрх зөрчлийг шийдвэрлэхэд хугацаа, ажиллагаа их шаардаж байна.
- 2.30. Зөрчлийн гомдол, мэдээлэл, хэргийг харьяаллын дагуу шилжүүлэхэд эрх бүхий албан тушаалтан санал бичиж, прокурор тогтоол үйлддэг байхаар шийдвэрлэх нь зүйтэй. Учир нь хуулийн зохицуулалтаар удирдах албан тушаалтан санал бичихээр байгаа нь давхардал үүсгэж байна.
- 2.31. Хуулийн 35-р бүлэгт зөрчлийн хэрэгт баталгаа авах, батлан даалтад өгөх зэрэг таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай нэмж тусгах нь зүйтэй.

Тайлбар: Эрх зүйн байдлыг дордуулна.

Хуульчид

1. П.Адьяасүрэн
2. Ц. Алдархишиг
3. С.Алминцэцэг
4. Ц.Алтангадас
5. Т.Алтантуяа
6. Н.Анхбаяр
7. Ч.Анхбаяр
8. Н.Арвинтариа
9. А.Ариунзаяа
10. Н.Баасанбат
11. Ц.Баасандэлгэр
12. А.Баатар
13. Д.Бадам
14. С.Байгалмаа
15. А.Бакыт
16. Д.Батгэрэл
17. А.Батгэрэл
18. Б.Батзориг
19. Г.Батнасан
20. Б.Бат-Орших
21. Д.Батсүх
22. П.Баттулга
23. Ж.Бат-Эрдэнэ
24. М.Баярсайхан
25. Д.Баярсүрэн
26. Б.Баярхүү
27. Т.Баясгалан
28. Ч.Болдбаатар
29. Д.Болдсайхан
30. Г.Болормаа
31. Д.Бурмаа
32. Г.Бямбадорж
33. Б.Галсанжамц
34. Б.Ганбаатар
35. Т.Ганбат
36. Б.Ганболд
37. В.Ганболд
38. А.Ганзориг
39. М.Гансүвд
40. С.Гансэлэм
41. Б.Гантулга
42. Б.Гэрэлмаа
43. Ц.Дайрийжав
44. С.Дангаасүрэн
45. Б.Дашдондов
46. Д.Дашцэрмаа
47. Г.Должинсүрэн
48. Б.Дуламсүрэн
49. Ш.Ербол
50. Б.Жавхланбаяр
51. Ч.Жадамба
52. У.Жамбацэрэн
53. Б.Жаргал
54. Ч.Жаргалбаатар
55. И.Золзаяа
56. М.Лхагвасүрэн
57. Б.Мангилик
58. Б.Манлайбаатар
59. Н.Манлайбаатар
60. Т.Мөнхбадрах
61. Т.Мөнхдалай
62. Т.Мөнх-Оргил
63. Ц.Мөнхчимэг
64. Ц.Мөнх-Эрдэнэ
65. Г.Наранбаатар
66. Т.Наранбат
67. Х.Наранзул
68. П.Нарантуяа
69. С.Номынбаясгалан
70. Э.Нэмэхжаргал
71. Э.Нямбилэгт
72. Х.Одбаяр
73. Н.Онон
74. Б.Отгон
75. Ч.Отгонсүрэн
76. В.Отгончимэг
77. Ц.Оч
78. М.Очирбат
79. С.Оюун
80. Д.Оюунбат
81. П.Оюунтунгалаг
82. Б.Оюунцэцэг
83. Г.Оюунцэцэг
84. П.Өлзийбаяр
85. М.Өлзийцэцэг
86. С.Өмирбек
87. У.Содбаяр
88. Б.Соёл-Эрдэнэ
89. Д.Сүнжид
90. Б.Сүрмандах
91. Ж.Тамир
92. М.Төрмөнх
93. Я.Туул
94. Ч.Түвшинжаргал
95. Т.Урангэрэл
96. Б.Уранцэцэг
97. Б.Уранчимэг
98. Ц.Уртнасан
99. Г.Халиунаа
100. Б.Хандмаа
101. Л.Хаш
102. В.Хосбаяр
103. З.Хүрэлбагана
104. Г.Цацрал
105. Б.Цогтбаатар
106. Д.Цэндсүрэн
107. С.Цэрэндорж
108. С.Цэцэгмаа
109. С.Цэцэгсүрэн
110. Х.Чекара
111. И.Чимэдбадам
112. М.Чинбат
113. Д.Чинзориг
114. М.Чинзориг
115. О.Чулуунцэцэг
116. Б.Энхбат
117. С.Энхбат
118. Ц.Энхбаяр
119. Д.Энхболд
120. Н.Энхжаргал
121. С.Энхзаяа
122. С.Энхмаа
123. Ж.Энх-Од
124. Л.Энхсайхан
125. З.Энхтайван
126. Ж.Энхтуяа
127. Н.Энхтуяа
128. Х.Эрдэм-Ундрах
129. Г.Эрдэнэбат
130. Б.Эрдэнэ-Очир
131. М.Эрдэнэсайхан
132. Э.Эрдэнэсувд
133. Л.Эрхзаяа

Төрийн бус байгууллагын ажилтнууд

134. А.Балдангомбо
135. Б.Баттогтох
136. Б.Баярмаа
137. Б.Баярмаа
138. Г.Ганбаясгах
139. Б.Жавзанхүү
140. Д.Мягмардорж
141. Б.Онон
142. Ч.Сэмжидмаа
143. Т.Цогзолмаа
144. П.Цэвээн
145. С.Цэндбаатар

Дугаарыг эрхэлсэн: **Б.ХИШИГСАЙХАН**
ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn

Хамтрагч байгууллага:



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО
Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Их
эзэн Чингис хааны нэрэмжит талбай-7, Хууль зүйн
үндэсний хүрээлэнгийн 4 давхар, 403 тоот
Утас: 70116007, 70116065
И-мэйл: info@mgllbar.mn